



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№68 /282/

2022.04.07

Цаг үе, үйл явдал

“ЦЭРГИЙНХЭН ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГААРАА МАНЛАЙЛАГЧ НЬ БАЙХ ЁСТОЙ”



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг Зэвсэгт хүчний 336 дугаар ангид ажиллалаа. Энэ үеэр тус ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Г.Гантөр ангийн товч танилцуулгыг хийж,

тулгамдаж буй зарим асуудлын талаар мэдээлэл өгөв.

Үүний дараа Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатар бие бүрэлдэхүүнтэй уулзсан бөгөөд тэрээр “Зэвсэгт хүчинд ажиллаж, алба хааж байгаа

хэн бүхэн ажилдаа сэтгэл зүрхээрээ хандаж, аливаад хариуцлагатай байх хэрэгтэй. Үүний тулд хүн бүр дор бүрнээ хичээж, цаг ямагт өөрийгөө хөгжүүлж, соёл түгээгч байх шаардлага өмнө тань тулгараад байгааг ухамсарлах хэрэгтэй. “Нийт нь нэгнийхээ төлөө, нэг нь нийтийнхээ төлөө” гэдэг

зарчмаар гар нийлэмжтэй ажиллах, зөв үлгэр дуурайлыг түгээж бай. “Нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино” гэдэг үг шиг хүн бүр сахилга баттай байж, ухамсартайгаар хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэх хэрэгтэй” гэв.

ЗЕНИТЧИД 85 ЖИЛИЙН ОЙГОО ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Монгол Улсад Цэргийг Агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 85 жилийн ойн баярыг тохиолдуулан “Нээлттэй өдөрлөг”-ийг баярын энэ өдөр амжилттай зохион байгууллаа.

Өдөрлөгт Зэвсэгт хүчний ХЗЦК-ын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Д.Өлзийбаяр, Цэргийг агаарын довтолгооноос хамгаалахын дарга, дэд хурандаа П.Мөнх-Эрдэнэ, “Зенитчдийн холбоо” ТББ-ын тэргүүн, бэлтгэл хошууч М.Ягаан, тус ангийн анхны захирагч, бэлтгэл хурандаа

Ж.Дагдан нарын олон хүндтэй зочид уригдан оролцсон юм.

Арга хэмжээний эхэнд тус ангийнхан нэгдсэн тооллогыг зохион байгуулж, үргэлжлүүлэн салбарын медаль болон уралдаан, тэмцээний аваргуудын шагналыг гардуулах ёслол болов. Тухайлбал, ангийн 2022 оны Марш тактик, тусгай бэлтгэлийн аваргууд болоод байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн үеэр “Онц буудагч”-аар шалгарч “Алтан хонгио”-ны эзнээр тодорсон Зенитийн пуужин артиллерийн дивизионы ахлах дэслэгч Б.Эрдэнэмөнх захирагчтай

Зенитийн пуужингийн цогцолборын батарейны хамт олныг “Зенитчдийн холбоо”-ныхон шагнаж урамшуулав.

“Мөнгөн хонгио”-ны эзнээр тодорсон Зенитийн артиллерийн дивизионы ахлах дэслэгч Д.Бат-Эрдэнэ захирагчтай 57 мм-ийн Зенитийн автомат бууны батарейны хамт олныг бэлтгэл хурандаа Т.Галиндэв агсны гэр бүлийн зүгээс хугацаат цэргийн алба хаагчдын сургалтад зориулж, иж бүрэн компьютер мөн бэлэглэлээ.

Үүний дараа үе үеийн зеничдэд илгээсэн Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал

Б.Амгаланбаатарын мэндчилгээг уншин сонордуулахын зэрэгцээ авьяаслаг хугацаат цэргийн алба хаагчдын урлагийн тоглолтыг үзэж, гурван үеийн зенитчдийн уулзалтыг тус тус зохион байгуулав. Уулзалтад зенитийн мэргэжлийн ангиудыг удирдаж байсан захирагч нар, ҮБХИС-ийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн Агаарын цэргийн тэнхимийн багш, дэд хурандаа Б.Чинзориг, хошууч Д.Мөнгөнхөлөг болон зенитийн мэргэжлээр суралцаж буй сонсогч нар оролцсон юм.

Б.ЭНХТУЯА

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2,272,557 /69.9%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,174,840 /66.8%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

1,033,548 31,8%
116,029 /3,6%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
8435 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
0

ЭДГЭРСЭН
8314

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 494,215,914

Эдгэрсэн

Нийт: 429,807,346

Нас барсан

Нийт: 6,183,655

ЭМД Зүүн мөнхийн гаалийн шалтгаалыг нь **ТӨР ХАРИУЦАН ТӨЛӨХ ИРГЭД**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2% -иар

- Тэтгэвэрээ өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн
- Нийгмийн халамжийн гэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өргөдөг иргэн
- Хүүхдээ 2 дугаар ба 3-р нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа иргэн
- Хугацаат цэргийн албан хаагч
- Ил эрэлж байгаа иргэн

сая 8,400T 0-----100,800T жилд

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1% -иар

- 0-18 насны хүүхэд

сая 4,200T 0-----50,400T жилд

Та өөрийн ЭМД-ын шалтгаал төлөхийн мэдээлэлд байгаа гарамсаа, хэлбэрэн шалтгаал болон бусад мэдээлэлд WWW.EMD.GOV.MN

Цахим шууданд

ЗЕНИТЧИН ДАЙЧИД БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ДУНД ХОЛИМОГ ГАР БӨМБӨГӨР ӨРСӨЛДЛӨӨ



Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Орчин цагийн Зэвсэгт хүчинд цэргийг агаарын довтолгооноос хамгаалахын цэрэг үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойн өдөрт зориулан Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн Зенитчин дайчид бие бүрэлдэхүүний дунд холимог гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж, хугацаат цэргийн алба хаагчдад Зенитчин дайчид дайны хүнд жилүүдэд үүргээ хэрхэн нэр төртэй биелүүлж, энх цагт ч эх орны бүтээн байгуулалт, хөгжил дэвшилд манлайлан оролцож байгаа талаар яриа танилцуулга хийж, асуулт хариултын тэмцээн зохион байгууллаа. Мөн тус ойг угтсан бүтээлч ажлын хүрээнд ариун цэврийн өрөөний өнгө үзэмжийг сайжруулж, засвар хийлээ.

“ХАЛУУН СЭТГЭЛ” ХАНДИВЫН ТОГЛОЛТ БОЛЛОО



Тус ангийн хөгжмийн салааны нарийн бүрээч дэд ахлагч Э.Отгонбилэгийн эмчилгээнд зориулсан хандивын урлагийн тоглолт Зүүнбаян соёлын төв ордонд болж өнгөрлөө. Тоглолтод

Дорноговь аймгийн “Саран хөхөө” театр, Зүүнбаян соёлын төв, ангийн хөгжмийн салааныхан уран бүтээлээ сонирхуулсан юм. Энэхүү хандивын тоглолтыг ангийн офицер, ахлагч, ажилтан

албан хаагч нийлсэн 170 гаруй хүн үзэж хандив өргөлөө. Мөн ангийн офицер, ахлагч нарын зөвлөлөөс 1 сая төгрөгийг дэд ахлагч Э.Отгонбилэгийн эмчилгээнд зориулан хандивлав.

Ахлах дэслэгч А.АЛТАНХУЯГ

ЁСЛОЛ, АЛБАНЫ БОЛОН ХЭЭРИЙН ХУВЦАСАНД ҮЗЛЭГ ХИЙЛЭЭ



Мөн ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс хугацаат цэргийн алба хаагчид болон ангийн эмэгтэйчүүдийн дунд “Гар бөмбөг”-ийн аварга хэсэг шалгаруулах тэмцээнийг зохиов. Тус тэмцээний тэргүүн байрт ахлах дэслэгч Д.Золзаяа ахлагчтай гуравдугаар хэсгийн баг, дэд байрт Н.Отгонбямба ахлагчтай тавдугаар хэсгийн баг, гутгаар байрт ахлах дэслэгч Н.Ууганцэцэг ахлагчтай дөрөвдүгээр хэсгийн баг тамирчид тус тус шагналт байрт шалгарлаа.

Б.БАТЗАЯА

Зэвсэгт хүчний 167 анги Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалын дагуу ангийн офицер, ахлагч нарын дулааны улирлын дүрэмт хувцасны үзлэгийг зохион байгууллаа. Энэ нь ЗХЖШ-ын даргын 2021 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-ийг бие бүрэлдэхүүнд мөрдүүлэх, жигдрэлтэд нь анхаарах, зөрчил дутагдлыг арилгуулах зорилготой юм. Мөн энэ үеэр албаны хувцасны мөрдэс, төмөр таних тэмдэг, сүүлд төгссөн сургуулийн энгэрийн тэмдэг, байгууллагын хүндэт тэмдэг, цэргийн мэргэжлийн зэргийн тэмдэг, одон, медалийн тууз, хатгамал ялгах тэмдэг зэргийг нь шалгаж, бүрдүүлэлт нь дутуу зарим цэргийн алба хаагчдыг зөрчлөө арилгах талаар хугацаатай үүрэг өглөө.



СОНСОГЧДОД ЛЕКЦ УНШИЖ, ТАНИН МЭДЭХҮЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн удирдлагын хүсэлтээр ЗХЖШ-ын Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаяр Цэргийн нэгдсэн дээд сургуулийн болон тус төвийн сонсогчдод лекц уншиж, танин мэдэхүйн сургалтыг зохион байгууллаа.

Тэр бээр сонсогчдод “Эх оронч үзэл, хүмүүжлийн зарим асуудлууд” сэдвээр лекц уншсаны зэрэгцээ сонсогчдын сонирхсон асуултад хариулж, сонирхолтой харилцан ярилцлагыг өрнүүлэв.

Энэхүү лекцийн дараагаар хэдхэн сарын дараа сургуулиа амжилттай дүүргээд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад томилогдон

идэвх зүтгэлтэй ажиллахын тулд өөрийгөө хэрхэн бэлтгэх талаар сонирхолтой ярилцлагыг өрнүүлэн ажил, албаны туршлагаа хуваалцсан юм. Мөн энэ үеэр цэрэг, эх орны сэдэвт өөрийн

шүлэг, яруу найргаа уншиж, мэндчилгээ дэвшүүлсэн нь сонсогчдын сэтгэлийг хөдөлгөн, тэдний талархлыг хүлээж байлаа.

Хошууч Ц.ПҮРЭВДОРЖ

ЗЕНИТИЙН МЭРГЭЖЛИЙГ СУРТАЛЧЛАВ



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Монгол Улсад Цэргийг агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 85 жилийн ойг тохиолдуулан

Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиуд “Зенитийн мэргэжил-Миний бахархал” өдөрлөгийг зохион байгууллаа. Энэ хүрээнд тус анги бүрэлдэхүүндээ зенитчдийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, ач

холбогдлын тухай танилцуулж, хамт олны дунд бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх зорилгоор сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж аваргуудаа тодрууллаа.

Таны сонорт



Ажилд урьж байна

БХЯ-ны “Соёмбо” редакц дараах ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтад урьж байна. Үүнд:

Зураглаач-эвлүүлэгч

Тавигдах шаардлага: Мэргэжлийн үнэмлэхтэй, 35 хүртэлх настай, мэргэжлийн дадлага, туршлагатай, офицерын албанд орж ажиллах хүсэл эрмэлзэлтэй байх,

Гэрэл зурагчин

Тавигдах шаардлага: Мэргэжлийн үнэмлэхтэй, 35 хүртэлх настай, мэргэжлийн дадлага, туршлагатай, хэвлэлийн эх бэлтгэл, дизайны программууд дээр ажиллах чадвартай, ахлагчийн албанд орж ажиллах хүсэл эрмэлзэлтэй байх.

АЖИЛД УРЬЖ БАЙНА

Нийслэлийн Тэргүүний Ерөнхий Боловсролын “Тэмүүжин Өрлөг” сургууль дараах ажлын байранд сонгон шалгаруулалт зарлаж байна.

1. Дизайн технологийн багш /эрэгтэй/
 2. Сургуулийн эмч
- Бүрдүүлэх материал:
 - Төрийн албан хаагчийн анкет
 - Дипломын хуулбар

Материал хүлээж авах хугацаа: 2022.03.31-04.07 / мэйлээр байж болно/
 Сонгон шалгаруулалт: 2022.04.11-нд “Тэмүүжин Өрлөг” сургууль дээр явагдана.
 Холбогдох дугаар: 99972727
 Мэйл хаяг: bsolongo514@gmail.com